



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 9/124

Хэрлэн сум


Сургалтын зардалд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.16, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" арвантавдугаар хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монгол бичиг үндэсний хөтөлбөрийн III"-хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагын албан хаагчдад Монгол бичгийн анхан, дунд шатны танхимын сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад нэн шаардагдах сургалтын хэрэглэгдэхүүний зардалд зориулан 3,874,000 (гурван саян найман зуун далан дөрвөн мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Хэнтий түүх бидэнд чухал" арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ